



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 3,933,230,400.00 (гурван тэрбум есөн зуун гучин гурван сая хоёр зуун гучин мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

3.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



0000874

Төрийн өмчийн бөдлөг, зохицуулалтын газрын
 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
 453 дугаар тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Д/д	Шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ		Шилжүүлэн авах байгууллага
					Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв	Зөөврийн компьютер - Dell Vostro ВТХ3580 /дагалдах хэрэгслийн хамт/	ш	2400	1,638,846.00	3,933,230,400.00	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НИЙТ ДҮН					3,933,230,400.00		
(гурван тэрбум есөн зуун гучин гурван сая хоёр зуун гучин мянга дөрвөн зуун)							